



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТЭС

УЛС БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН ТАЙЛАНГААС





“Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”



Ерөнхий мэдээлэл



“Монгол улсын 2024 оны төсвийн тухай” хуулийн хоёрдугаар хавсралтаар “Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг баталсан байна. Дээрх жагсаалтаас Нийслэлийн засаг даргад 13 ТЭЗ-ийн 1,038,127.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 142 төсөл, арга хэмжээг 325,992.9 сая төгрөгөөр санхүүжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Нийслэлийн Засаг даргад улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 455,728.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 187 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж байсан бол 2024 онд 1,038,127.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 142 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 56.1 хувиар өссөн байна.

Эрх шилжсэн нийт ТАХ-ний 64.1 хувийг барилга, байгууламж, 23.2 хувийг тоног төхөөрөмж, 10.6 хувийг их засвар, 2.1 хувийг ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ эзэлж байна.



Аудитад төлөвлөлт, худалдан авалт, өмч ашиглалт, бүртгэлтэй холбоотой асуудлыг бүрэн, санхүүжилт, захиалагчийн хяналттай холбоотой асуудлын 45.8 хувийг түүвэрт хамрууллаа.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 157 төсөл, арга хэмжээнээс 58 хувь нь хугацаандаа хэрэгжиж, 9 хувь нь гэрээний хугацаа болоогүй, 33 хувь нь гэрээний хугацааг хэтрүүлж сунгасан, гэрээг хүчингүй болгосон, хэрэгжилт удааширсан байна.



“Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?



Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 30 хувь нь “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй, 78.3 хувь нь “Монгол Улсын хөрөнгө оруулалтын жилийн хөгжлийн төлөвлөгөө”-тэй уялдаагүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн үү?



Нийслэлийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төслийн саналыг хүргүүлэхдээ холбогдох аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.



Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, урсгал зардлын тооцоололтой, төсөвлөлтийн холбогдох бусад шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан уу?



Нийслэлийн Засаг даргад төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

.....



“Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?



Шинээр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарахгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны журмыг зөв сонгон хэрэглэсэн ч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж батлаагүй, хуулийн хугацаанд эрхийг шилжүүлээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан ч гүйцэтгэлийн баталгаатай холбоотой заалтыг тендерийн баримт бичигт тусгаагүй байна.

Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?

Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг тендерийн баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.





Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлийг үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?



Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 67.2 хувьд нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?



Зарим төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй, батлагдсан зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна.

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн 88.9 хувийг данс бүртгэлд тусгасан байна.



Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:



1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталж Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлснээс шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсвийн 44.9 хувь нь татагдсан байна.

2. Худалдан авах ажиллагааг ажлын даалгавраар зарлаж, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагад зураг, төсөвгүй, магадлалын дүгнэлтгүй, дүгнэлтийн хугацаа хэтэрсэн, нэг маягийн зураг төсөлтэй төсөл, арга хэмжээг эрх шилжүүлдгээс шалтгаалж хэрэгжилт удааширсан байна.

3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн ч зарим ажилд гүйцэтгэл давхардуулан бичих, баримт материал бүрэн бус зөрчил илэрч байна.

4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 67.2 хувьд нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.

5. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн 88.9 хувийг данс бүртгэлд тусгасан байна.



“Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

НИЙСЛЭЛ ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИД:



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлсэн зураг төсөвгүй, магадлалын дүгнэлтгүй, газрын болон техникийн нөхцөлийн зөвшөөрөлгүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх,

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-Т:



Захиалагчийн хяналтыг холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

